

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2024 оны 12 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 1 зорилтын 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хяналт шинжилгээний ажлыг **гүйцэтгэхдээ** Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийв.

Хяналт шинжилгээ хийсэн талаар:

Нийт 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт нь 100%-3 арга хэмжээ тус тус ханган ажилласан бөгөөд ерөнхий үнэлгээгээр 100%-ийн хэрэгжилттэй байна

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦАН
МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХБААТАР

Г.АРИУНТУНГАЛАГ

Г.ДӨЛГӨӨН

НИЙСЛЭЛИЙН АГААР ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 16-ний өдөр							Улаанбаатар хот
Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь / Дээд шатны байгууллагын үнэлгээ, тайлбар
1	9.2. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.	9.2.4. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын бүх эх үүсвэрийг багасгаж, дахин ашиглах саармагжуулах боломжийг бүрдүүлнэ.	2020-2050	139,0	Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар халаалтын зуухыг шинэчилсэн байна.	НЗДТГ, НАОБТГ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Гэр хороололд сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг дэмжих замаар амьжиргааг нэмэгдүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Энэхүү төсөлд сэргээгдэх эрчим хүчинд шилжүүлэхээр 69 айл өрхөд хийгдээд байна. Уг төсөл нь Сонгинохайрхан дүүргийн 31,43-р хорооны 6 өрхөд бүрэн сууриллуулсан. Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт нийт 39 өрхөд суурилуулсан байна. Эрдэнэт хотын 24 өрхийн нүүрсний хэрэглээг нарны эрчим хүчээр орлуулж байна. Төслийн үр дүнд өрх бүр нүүрстөрөгчийн ялгаруулалтыг жил тутам 10-20 тонноор бууруулж, эрчим хүчний зардлаа 70 хүртэл хувиар хэмнэх, цаашлаад төсөлд хамрагдсан өрхүүд нүүрстөрөгчийн кредит борлуулсанаар нэмэлт орлоготой болох боломж бүрдэх юм.	100%

						2024 оны хагас жилийн байдлаар Уурын болон 100 кВт-аас дээш хүчин чадалтай, агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх ажлын удирдамжийн дагуу 2023.12.01-ний өдрөөс 2024.04.01-ний өдрийг хүртэл хугацаанд нийт 186 ААНБ-ын 342 халаалтын зуух бүртгэгдэж, магадлан итгэмжлэл хийж ажилласан. Томоохон эх үүсвэрийн тоо өмнөх онтой харьцуулахад 16,5 хувиар буурч, төвлөрсөн дулаан, хий болон бусад дэвшилтэт технологид шилжсэн үзүүлэлттэй байна. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Агаар, орчны бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардлын хуваарь батлах, эрх шилжүүлэх тухай” А/163 тушаалаар Ерөнхий боловсролын 143 дугаар сургуулийн халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох зураг төсөв боловсруулах ажлын санхүүжилтийг шийдвэрлэн, зураг төсөв гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулахаар үнэлгээний хороонд орж ажиллах албан хаагчдыг нэрийг Худалдан авах ажиллагааны газарт албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай А/1015	
--	--	--	--	--	--	--	--

						захирамжийн хавсралтад заасан “Улсын болон орон нутгийн өмчит байгууллагын усан халаалтын зууханд техникийн шинэчлэлт хийх” ажлыг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/92 тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зарлаж тендерийн нээлтийг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр нээсэн. Тус тендерт “Дашваанжил” ХХК, “Таван хан энерги” ХХК-ууд материалаа ирүүлсэн. Тус 2 компани ерөнхий шаардлага хангаагүй тул түдгэлцүүлж 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдөр дахин зарласан. 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр дахин тендерийн нээлтийг хийхэд “Таван хан энерги” ХХК материал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй тул тендерийг дахин зарлаад байна. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 -ний өдрийн “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах А/1015 захирамжийн хүрээнд: “Ногоон технологи-2024” үзэсгэлэнг 9 дүгээр сарын 18,19-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулж 85 н аж ахуй нэгж байгууллага, 5000 гаруй иргэдийг хамруулсан. Мөн угаарын	
--	--	--	--	--	--	---	--

						хийн хордлогоос урьдчилан сэргийлье, зуухаа зөв галлах зааварчилгаа, байшин сууц хаагуураа дулаанаа алддаг талаар, хямд аргаар хэрхэн гэрээ дулаалах зэрэг мэдээлэл багтаасан нийт 1200 гаруй брошурыг иргэд олон нийтэд танилцуулж тараан хүргэсэн. Мөн Өглөө.мн, Улстөрч агентлаг.мн, Монголынмэдээ.мн, serune.mn зэрэг тус тус сайтуудаар тус өдөрлөгийн талаар видео болон ярилцлага үйл явдлын мэдээ, сурвалжлага зэрэг мэдээллийг олон нийтийн хэрэгслээр түгээж нийт 10,000 гаруй иргэд олон нийтэд хүрсэн байна.	
2		9.2.12. Орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2020-2050	50,0	Орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлнэ.	Орчны агаарын чанарыг хэмжигч явуулын AQMS-9000 хөдөлгөөнт станцаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд иргэн, ААНБ-н хүсэлтээр нийт 48 хэмжилт хийж дүнг (MNS458:552016) стандарттай харьцуулан холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Орчны агаарын чанарын тоос, тоосонцор хэмжих DUSTTRACK-8533 2 ширхэг төхөөрөмжийг үйлдвэрийн тохиргоонд явуулах ажлыг зохион байгуулах тухай газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/21 дугаар тушаал гарсан. Үүнтэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулж төхөөрөмжийг үйлдвэрийн	100%

						тохиргоонд явуулах ажлын даалгаврыг батлуулан, албан ёсны эрхтэй компаниудаас ирүүлсэн үнийн саналыг харгалзан үзэж тус ажлыг гүйцэтгэх компаниар "Technic Monde" ХХК-ийг ажлыг хэсгийн гишүүдийн 100%-ийн саналаар сонгож 2024.04.10-ны өдөр гэрээ байгуулан төхөөрөмжийг засвар үйлчилгээнд явуулж хүлээж авсан. Нийслэлийн засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай А/1015 тоот захирамжаар байгуулагдсан "Орчны агаарын чанарын хяналт шинжилгээний явуулын станц болон суурин харуулын тоног төхөөрөмж шинэчлэх" ажлын хэсэг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 2024 оны 08 дугаар сарын 27-ний өдрийн А/93 тоот тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан нээлттэй тендерийг 2 удаа зарласан. Багц 1. Орчны агаарын чанарын хяналт шинжилгээний явуулын станц-1ш" худалдан авах тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг үндэслэн бараа худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. Тус тендерт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр	
--	--	--	--	--	--	---	--

						бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг үндэслэн "ЭМ АЙ ЭС ЭС" ХХК-тай 894,497,498 (найман зуун ерэн дөрвөн сая дөрвөн зуун ерэн долоон мянга дөрвөн зуун ерэн найм) төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн үнэлгээний хорооны зөвлөмж гарсан. Багц 2. БОУАӨЯ-д суурин харуулын тоног төхөөрөмжийн тоо хэмжээг багасгах санал хүргүүлсэн. Суурин харуулын өвлийн бэлтгэл ажил хангах, хэмжилтийн тасралтгүй ажиллагааг хангуулах ажлын хүрээнд ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, 2024.04.10-ны өдөр А/28 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан Интерсайнс ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр НАОБТГ-03/15 тоот гэрээ байгуулан гэрээний хугацаанд тус ажлыг хийж гүйцэтгэн 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр бүрэн хүлээлгэн өгсөн.	
3		9.2.13. Авто тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулна.	2020 - 2050	-	Тээврийн хэрэгслийн яндангаас ялгаруулах хорт бодисын хэмжээг бууруулна.	Авто замын хөдөлгөөнд оролцож буй дизель хөдөлгүүрт нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт урьдчилсан сэргийлэх удирдамжийн хүрээнд Зорчигч Тээвэр- 1, 2 ОНӨААТҮГ, АПУ ХК-ий нийт 455 тээврийн хэрэгсэл хамрагдаж,	100%

						холбогдох баримт бичигт хяналт шалгалт хийж хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлээ.	
Дундаж дүн							100

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.АРИУНТУНГАЛАГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТӨВӨЛЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Р.ЖАМБАЛСҮРЭН